

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын дүнгийн тухай

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго: 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ. Энэхүү хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнгийн талаар байгууллагын удирдлагыг бодит мэдээллээр хангах, хангалтгүй хэрэгжсэн зорилт, арга хэмжээний шалтгааныг тодорхойлох, гүйцэтгэлийн тайлан гаргах үйл ажиллагаанд цаашид анхаарах санал, зөвлөмж гаргахад чиглэсэн болно.

Хоёр.Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулсан арга зүй: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтооолоор шинэчлэн батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ыг удирдлага болгов.

Гурав.Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын дүн: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 3 стратегийн зорилго, 27 хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ, 9 зорилтын хүрээнд нийт 60 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллаа.

№		Зорилтын тоо	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ								Хувь
				100	90	70	50	30	0	x/b		
1	Зорилт 1. Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна.	1	2	2	-	-	-	-	-	-	100%	
2	Зорилт 2. Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг,	1	31	25	3	-	-	-	-	3	99%	

	өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ.										
3	Зорилт 3. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна.	1	7	6	-	-	-	-	-	1	100%
4	Зорилт 4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг бүрэн хангана.	1	3	3	-	-	-	-	-	-	100%
5	Зорилт 5. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	1	3	3	-	-	-	-	-	-	100%
6	Зорилт 6. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл технологийг сайжруулна.	1	3	3	-	-	-	-	-	-	100%
7	Зорилт 7. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайлаар хангана.	1	5	5	-	-	-	-	-	-	100%
8	Зорилт 8. Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан, ил тод байдлыг ханган ажиллана.	1	3	3	-	-	-	-	-	-	100%
9	Зорилт 9. Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулна.	1	3	3	-	-	-	-	-	-	100%
Нийт			60	53	3					4	

Дөрөвдүгнэлт: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, мөн “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын дагуу хэрэгжилтийг дараахь ангилалд шилжүүлэн тооцоход 2025 оны эхний хагас гүйцэтгэлийн төлөвлөгөөний 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаарх гүйцэтгэл 99% буюу “Үр дүн гарсан” үнэлгээтэй байна.

Арга хэмжээнүүдийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чанарын үзүүлэлт нь:

- 100 хувийн хэрэгжилттэй 56 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 93.3 хувийг,
- Хугацаа болоогүй 4 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 6,7 хувийг эзэлж байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 06 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Хувь
1	2	3	4	5	6	7	

Зорилго 1. Хөгжлийн бодлогын барим бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

1	Зорилт 1. Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна.						
1.1	Арга хэмжээ 1.1. НХТЖҮЧ-4.1.1 Нийслэлийн өмчийн байр талбайг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төвлөрүүлэх төсөвт орлогыг нэмэгдүүлэх	-	Түрээсийн орлого, сая.төг	3,068.9	2,300	<p>НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын дагуу иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудтай нийслэлийн өмчийн барилга, байгууламжийн турван талт гэрээ 140, хоёр талт гэрээ 27, Үйдийн цай хөтөлбөрийн 35, нийт 202 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажиллаж байна.</p> <p>2025 оны түрээсийн жилийн орлогын төлөвлөгөөг 3,068.9 сая төгрөгөөр баталж, түрээсийн орлого төвлөрүүлэх батлагдсан хуваарийн дагуу 895,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025.06.12-ны өдрийн байдлаар 861,7 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөв төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолд заасан түрээсийн төлбөрийн доод хязгаарын 1мкв үнэ 6,000-15,000 тогтоосон байна.</p> <p>НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх</p>	100%

					түрээслэгчийг сонгон шалгаруулах журам” дагуу сонгон шалгаруулалт зохион байгууламж Нийслэлийн өмчийн байр талбайг иргэн, аж ахуй нэгжид 1 мкв талбайг 25,000-45,000 түрээслүүлэн ажиллаж байна.	
1.2	Арга хэмжээ 1.2 ЗДУАХ-3.2.5 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн мэдээллийг нэгтгэн боловсруулах их өгөгдлийн системийг хөгжүүлэн, бүтэц эдийн засгийн зорилтод түвшнийг оновчтой тодорхойлж, орон нутгийн өмчит эдийн засгийн эрэлтэд оруулах замаар үр ашгийг нэмэгдүүлэх	Хөрөнгийн дүн, сая төг	-	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн мэдээллийг нэгтгэнэ. Нийслэлийн өмчийн менежментийг сайжруулан нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь нэмэгдсэн байна.	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.5. “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн мэдээллийг нэгтгэн боловсруулах их өгөгдлийн системийг хөгжүүлэн, бүтэц, эдийн засгийн зорилтод түвшнийг оновчтой тодорхойлж, орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.” зорилтын 3 арга хэмжээний саналыг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн өмчийн бүртгэлийн удирдлагын системд нийслэлийн өмчит хуулийн этгээдийн өмчийн мэдээллийг оруулах; - Эдийн засгийн эргэлтэд оруулах орон нутгийн өмчийг тодорхойлох; - Ногдол ашиг төвлөрүүлэх; <p>Дээрх санал өгсөн арга хэмжээнд туссан ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - НЭДТГ-ын захиалагчийн хяналт тавьж, 2024.05.20-ны өдрөөс эхлүүлсэн “Нийслэлийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын системийг хөгжүүлэх” төслийн ажлын хүрээнд 2025 оны 3 -р сард системийн гүйцэтгэгч Ухаалаг шийдэл ХХК төлөвлөгөөний дагуу байгууллагын албан хаагчдад 5, хуулийн этгээдэд 1 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан. Захиалагч НЭДТГ ажлын даалгаврын ажилбар тус бүрээр гүйцэтгэлийг тулгалт хийх ажил хийгдэж, хүлээж авах хугацаа сунгах захирамжийн төсөл боловсруулах, - ТӨБЗГ-ын чиглэлийн дагуу “эдийн засгийн эргэлтэд оруулах орон нутгийн өмчийг тодорхойлох” ажлын хүрээнд нийслэлийн өмчийн болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн 	100%

						<p>этгээдийн 2023, 2024 оны санхүүгийн мэдээлэл, бүтэц орон тоо, үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн,</p> <ul style="list-style-type: none"> - 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар нийслэлийн өмчтэй хуулийн этгээдийн нийслэлд төвлөрүүлэх ногдол ашгийн нэгдсэн тооцоо, судалгааг боловсруулж байна. 	
Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана. (Хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийн хэрэгжүүлэх зорилго)							
2	Зорилт 2. Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийт нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ.						
2.1	Арга хэмжээ 2.1 Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн (УЗ) гишүүнийг томилох, чөлөөлөх, өөрчлөлт оруулах санал боловсруулж НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлэх	-	Хуулийн этгээдийн тоо, гишүүдийн тоо	31 173	НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлсэн байна.	Нийслэлийн өмчтэй хуулийн этгээдүүдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн өмчтэй компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороод нээлттэй зохион байгуулж шалгаруулсан. Шалгарсан нэр дэвшигчдээр ХАСУМ бөглүүлэн Авлигатай тэмцэх газарт хянуулан ашиг сонирхлын зөрчлийг хянуулж, зөрчилгүй хариу гарсан нэр дэвшигчдийг 2024.12.04, 2025.1.27, 2025.04.15, 2025.05.23-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн 24/17, 25/18, 25/62 дугаар тогтоолуудаар ТУЗ-ийн гишүүдийг томилж, чөлөөлөх асуудлыг шийдвэрлүүлсэн.	100%
2.2	Арга хэмжээ 2.2 ТУЗ, УЗ-ийн удирдлага, гишүүд, хараат бус гишүүн, байгууллагын албан хаагчдыг компанийн засаглалын сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан хүний тоо, хувь	10	10	Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн (УЗ) удирдлага, гишүүдэд компанийн засаглалын сургалтын гэрчилгээтэй иргэд, албан хаагчдыг томилсон. ТУЗ, УЗ-д гишүүнээр ажиллаж байгаа байгууллагын 6 албан хаагч сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байна.	100%

2.3	Арга хэмжээ 2.3 Нийслэлийн Өмч хувьчлалын комисс (НӨХК)-ын хурлыг зохион байгуулах, хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлэх	-	Жагсаалт дахь хөрөнгийн тоо	Жагсаалтаас хассан барилга 13	10	<p>Нийслэлийн өмч хувьчлах комиссын хурлыг 2025.04.15, 2025.05.02-ны өдрүүдэд 2 удаагийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэн НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/371 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн “Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Уламжлалт анаагаах ухааны элэг судлалын клиник төв”-ийг “Менежментийн гэрээгээр ажиллуулах тухай” Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2008.09.08-ны өдрийн 73 дугаар тогтоолыг НИТХ-ын 2025 оны 25/35 дугаар тогтоолоор хүчингүй болгосон; - Хувьчлалын жагсаалтын 30 барилгаас 6 барилгыг акталь нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг өргөн барьж НИТХ-ын 2025 оны 25/78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. 	100%
2.4	Арга хэмжээ 2.4 НИТХ-ын тогтоолоор батлагдсан хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын дагуу нийслэлийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулах,	-	Хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн тоо, Дүн, сая төгрөг	295,206 ш хувьцаа 699.2	10 2,000.0	<p>Нийслэлийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд дараах асуудлыг НИТХ, ТӨБЗГ-д өргөн барьж шийдвэрлүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - НИТХ-ын 2025.03.28-ны өдрийн 25/53 дугаар тогтоолоор Нийслэлийн өмчөөс 2025 онд хувьчлах эд хөрөнгийг жагсаалт, - ТӨБЗГ-ын 2025.05.01-ний өдрийн 214 дүгээр тогтоолоор Нийслэлийн өмчөөс 2025 онд хувьчлах жагсаалтыг ёсоор дэмжин шийдвэрлэсэн, - НИТХ-ын 2025.05.23-ны өдрийн 25/78 дугаар тогтоолоор 2010 онд хувьчлагдах жагсаалтын 3 барилга байгууламжийг хасах. <p>Нийслэлийн өмчийг хувьчлах бэлтгэл ажлын хүрээнд нээлттэй дуудлага худалдаагаар худалдах барилга байгууламжийн мэдээллийг НЭДТ, НӨХГ-ын https://www.facebook.com/share/p/1NrL4jLymh/, https://www.facebook.com/share/p/12Mf32cw7EC/ цахим хуудаст иргэд, аж ахуйн нэгжид ил тод, нээлттэй нийтэлж байна.</p>	100%

2.5	Арга хэмжээ 2.5 ОНӨААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг дүгнэх ажлыг зохион байгуулж, үнэлгээг нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулах	-	ОНӨААТҮГ-ын тоо, Нийт орлого, зардал, алдагдлын дүн, сая төг	15 Орлого 462,644.7, Зардал 484,282.6, Алдагдал 21,737.9	Ажлын үр дүнг тухайн хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэл болон бусад албан ёсны мэдээлэлд үндэслэн дүгнэсэн байна.	<p>Нийслэлийн өмчийт 18 аж ахуй тооцоот үйлдвэрийн газруудын 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний төслийг боловсруулан, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох бичиг баримтын хамт ирүүлэх тухай Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2025 оны 1/174 тоот дугаартай албан бичиг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ Орлого- 142,268,464.1 мян.төг Зардал- 133,168,449.3 мян.төг Ашиг, Алд- 9,100,014.8 мян.төг - “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ Орлого- 146,225,622.1 мян.төг Зардал- 154,983,427.0 мян.төг Ашиг, Алд- (8,757,804.9) мян.төг - Хөрөнгө оруулалтын газар Орлого- 7,468,012.5 мян.төг Зардал- 5,631,853.4 мян.төг Ашиг, Алд- 1,836,159.1 мян.төг - Хот тохижилтын газар ОНӨААТҮГ Орлого- 6,117,048.9 мян.төг Зардал- 5,760,319.3 мян.төг Ашиг, Алд- 356,729 мян.төг - Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ Орлого- 52,814,452.8 мян.төг Зардал- 47,361,431.2 мян.төг Ашиг, Алд- 5,453,021.6 мян.төг - Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ Орлого- 15,594,561.7 мян.төг Зардал- 12,796,878.6 мян.төг Ашиг, Алд- 2,797,683.1 мян.төг - Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ Орлого- 16,793,926.2 мян.төг Зардал- 16,587,523.4 мян.төг Ашиг, Алд- 206,402.8 мян.төг - Хүнс хангамж ОНӨААТҮГ Орлого- 7,912,576.4 мян.төг 	90%

					<ul style="list-style-type: none"> - Зардал- 7,753,198.6 мян.төг Ашиг, Алд- 159,377.8 мян.төг - Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ Орлого- 12,422,489.3 мян.төг Зардал- 12,222,977.9 мян.төг Ашиг, Алд – 199,511.4мян.төг - "Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ Орлого- 2,087,402.5 мян.төг Зардал- 1,884,183.4 мян.төг Ашиг, Алд – 203,219.0 мян.төг - Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ Орлого- 22,087,337.1 мян.төг Зардал- 23,658,451.8 мян.төг Ашиг, Алд - (1,571,114.6) мян.төг - Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ Орлого- 21,593,159.3 мян.төг Зардал- 22,812,161.8 мян.төг Ашиг, Алд - (1,219,002.5) мян.төг - Улаанбаатар зам засвар, арчлалтын газар Орлого- 39,439,447.1 мян.төг Зардал- 39,396,571.5 мян.төг Ашиг, Алд – 42,875.6 мян.төг - Багачууд хүнс ОНӨААТҮГ Орлого- 5,497,173.7 мян.төг Зардал- 5,311,291.6 мян.төг Ашиг, Алд – 185,882.- мян.төг - Геодези усны барилга байгууламж ОНӨААТҮГ Орлого- 18,739,260.2 мян.төг Зардал- 20,633,450.9 мян.төг Ашиг, Алд - (1,894,190.6) мян.төг - "Хот тохижилтын газар Орлого- 17,976,889.6 мян.төг Зардал- 21,040,018.37 мян.төг Ашиг, Алд - (3,063,128.7) мян.төг - Асгат ОНӨААТҮГ Орлого- 4,530,579.8 мян.төг Зардал- 4,737,161.5 мян.төг Ашиг, Алд - (206,581.7) мян.төг 	
--	--	--	--	--	--	--

						<ul style="list-style-type: none"> - Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар ОНӨААТҮГ Орлого- 15,983,524.4 мян.төг Зардал- 16,587,308.9мян.төг Ашиг, Алд - (603,784.4) мян.төг Дээрх газруудаас ирүүлсэн зорилтот түвшний төслийг хянаж байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2025 оны 1/869 тоот албан бичгээр захирамжийн төсөлд санал авч байна. 	
2.6	Арга хэмжээ 2.6 ОНӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг батлуулах ажлыг зохион байгуулж, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулах	-	ОНӨААТҮГ-ын тоо Орлого, зардал, алдагдлын дүн, сая төг	15 Орлого 477,938.3, Зардал 514,042.5, Алдагдал 36,125.3	19 Орлого 478,188.3 Зардал 514,102.5 Алдагдал 35,914.2	<p>Нийслэлийн өмчит 19 аж ахуй тооцоот үйлдвэрийн газруудын 2025 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний төслийг боловсруулан, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох бичиг баримтын хамт ирүүлэх тухай Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2025 оны 1/174 тоот дугаартай албан бичиг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ Орлого- 145,692,365.0 мян.төг Зардал- 180,359,989.9 мян.төг Ашиг, Алд - (34,667,624.6) мян.төг - "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ Орлого- 157,028,170.7 мян.төг Зардал- 186,747,321 мян.төг Ашиг, Алд - 29,719,150.3 мян.төг - Хөрөнгө оруулалтын газар Орлого- 10,081,057.2 мян.төг Зардал- 9,732,571.8 мян.төг Ашиг, Алд – 313,636.9 мян.төг - Хот тохижилтын газар ОНӨААТҮГ Орлого- 8,349,210.2мян.төг Зардал- 8,175,493.2 мян.төг Ашиг, Алд – 173,717.0 мян.төг - Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ Орлого- 50,126,389.1мян.төг Зардал- 53,258,834.5 мян.төг Ашиг, Алд - (3,132,445.4) мян.төг 	90%

					<ul style="list-style-type: none"> - Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ Орлого- 36,590,100.0мян.төг Зардал- 36,264,670.0 мян.төг Ашиг, Алд – 325,400.0 мян.төг - Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ Орлого- 41,499,346.3мян.төг Зардал- 45,707,532.8 мян.төг Ашиг, Алд -4,208,186.5 мян.төг - Хүнс хангамж ОНӨААТҮГ Орлого- 11,135,353.8 мян.төг Зардал- 11,045,353.2 мян.төг Ашиг, Алд – 43,450.5 мян.төг - Θсвэр үе хүнс” ОНӨААТҮГ Орлого- 14,530,287.9 мян.төг Зардал- 14,487,070.5 мян.төг Ашиг, Алд – 38,865.7 мян.төг - “Гэрлэх ёслолын ордон” ОНӨААТҮГ Орлого- 2,725,840.0 мян.төг Зардал- 2,705,786.1 мян.төг Ашиг, Алд – 18,048.48 мян.төг - Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ Орлого- 66,662,068.0 мян.төг Зардал- 68,948,710.6мян.төг Ашиг, Алд - (2,286,642.6) мян.төг - Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ Орлого- 52,379,293.4 мян.төг Зардал- 54,872010.7 мян.төг Ашиг, Алд - (2,492,717.3) мян.төг - Улаанбаатар зам засвар, арчлалтын газар Орлого- 47,149,151.2 мян.төг Зардал- 47,104,616.7 мян.төг Ашиг, Алд -40,081.0 мян.төг - Багачууд хүнс ОНӨААТҮГ Орлого- 1,232,915.07 мян.төг Зардал- 1,124,019.0 мян.төг Ашиг, Алд- 98,006.4 мян.төг - Геодези усны барилга байгууламж ОНӨААТҮГ Орлого- 35,207,769.2 мян.төг 	
--	--	--	--	--	--	--

						<p>Зардал- 33,013,135.9 мян.төг Ашиг, Алд- 21,194,633.3 мян.төг</p> <ul style="list-style-type: none"> - "Хот тохижилтын газар Орлого- 14,791,870 мян.төг Зардал- 14,763,844 мян.төг Ашиг, Алд- 28,026,456 мян.төг - Асгат ОНӨААТҮГ Орлого- 5,987,633.3 мян.төг Зардал- 5,827,837.8 мян.төг Ашиг, Алд- 143,816.0 мян.төг - Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар ОНӨААТҮГ Орлого- 16,548,019.5 мян.төг Зардал- 16,548,019.5 мян.төг Ашиг, Алд- 0.0 мян.төг - Нийслэлийн авто тээврийн хэрэгсэл бүртгэл, хяналтын төв Орлого- 7,324,606.8 мян.төг Зардал- 3,880,189.6 мян.төг Ашиг, Алд- 3,099,975.5 мян.төг <p>Дээрх газруудаас ирүүлсэн зорилтот түвшний төслийг хянаж байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2025 оны 1/869 тоот албан бичгээр захиралттай төсөлд санал авч байна.</p>	
2.7	Арга хэмжээ 2.7 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ" байгуулах ажлыг зохион байгуулах	-	Гэрээ байгуулсан хуулийн этгээдийн тоо	15	19	Терийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-ын дагуу Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захиралтай 2025 оны "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ"-г байгуулах захиралттай төсөлд санал авч байна.	90%
2.8	Арга хэмжээ 2.8 Нийслэлийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайлангийн цэвэр	-	Хуулийн этгээдийн тоо, ногдол ашгийн дүн, сая төг	6 1,340.5	9 1,533.8	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь	ХБ

	ашигас 2025 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тогтоон, НИТХ-аар батлуулах					хэмжээг тогтоон, НИТХ-аар батлуулах тогтоолын төслийн шийдвэрлэх тайлант хугацаа болоогүй. - 2025 оны III улиралд НИТХ-аар хэлэлцүүлнэ.	
2.9	Арга хэмжээ 2.9 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг шинээр байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах ажлыг зохион байгуулан, дүрэм, бүтэц, орон тоог судлан санал боловсруулж, НИТХ, Нийслэлийн Засаг даргад өргөн барьж шийдвэрлүүлэх	-	Өөрчлөн байгуулсан хуулийн этгээдийн тоо	15	10	<p>Нийслэлийн өмчит 9 аж ахуй тооцоот үйлдвэрийн газруудын бүтэц, орон тоог судлан санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын 2025 оны захирамжаар баталсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 2025 оны A/666-р захирамжаар УСУГ ОНӨААТҮГ 2025 оны A/312-р захирамжаар ОСНААУГ ОНӨААТҮГ 2025 оны A/119-р захирамжаар Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ 2025 оны A/121-р захирамжаар Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ 2025 оны A/225-р захирамжаар Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 2025 оны A/389-р захирамжаар Хот тохижилтын газар ОНӨААТҮГ 2025 оны A/522-р захирамжаар Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ 2025 оны A/312-р захирамжаар Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар 2025 оны A/261-р захирамжаар Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ 	100%
2.10	Арга хэмжээ 2.10 Нийслэлийн өмчийн төсөвт байгууллагын удирдлагатай байгуулсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2024 оны биелэлтийг дүгнэх	-	Хамрагдсан байгууллагын тоо, Үнэлгээний дүн	168 Бүрэн хангалттай 83, Хангалттай 65, Ажил сайжруулах 16, Хангалтгүй 3, Үнэлэгдээгүй 1	170 Батлагдсан үндсэн үзүүлэлтийн дагуу дүгнэсэн байна.	“Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2024 оны биелэлтийг дүгнэх тайлант хугацаа болоогүй. - 2025 оны III улиралд дүгнэнэ.	XБ
2.11	Арга хэмжээ 2.11	-	Байгууллагын тоо,	771 -	Байгууллагын удирдлага солигдсон тохиолдолд	НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх	XБ

	“Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулах ажлыг зохион байгуулах	Хүлээлгэн өгсөн хөрөнгийн дүн		Өмч эзэмшийн гэрээг шинэчлэн байгуулж, санхүүгийн тайландаа тусгагдсан эргэлтийн бус хөрөнгийг актаар хүлээлгэн өгсөн байна.	гэрээ” байгуулах ажлыг зохион байгуулах Тайлант хугацаа болоогүй. - 2025 оны III,IV улиралд		
2.12	Арга хэмжээ 2.12 Нийслэлийн өмчийн байр талбайн ашиглалтыг сайжруулж, үр ашигийг дээшлүүлэн, нийслэлийн өмчтэй хуулийн этгээдийн илүүдэлтэй байр, талбайг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх үйл зохион ажиллагааг байгуулах	-	Түрээсийн гэрээний тоо, Түрээсийн гэрээний үнийн дүн, сая төг	312 - 312	312 Гэрээний хавсралтаар түрээсийн үнийн дүнг баталсан байна.	НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам”-ын дагуу иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудтай нийслэлийн өмчийн барилга, байгууламжийн турван талт гэрээ 140, хоёр талт гэрээ 27, Үдийн цай хөтөлбөрийн 35, нийт 202 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажиллаж байна. 2025 оны түрээсийн жилийн орлогын төлөвлөгөөг 3,068.9 сая төгрөгөөр баталж, түрээсийн орлого төвлөрүүлэх батлагдсан хуваарийн дагуу 895,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025.05.30-ны өдрийн байдлаар 823.6 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.	100%
2.13	Арга хэмжээ 2.13 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, бусад хуулийн этгээдийн комисст орж ажиллан, хяналт тавих	-	Сонгон шалгаруулалт ын тоо,	14	14	Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах 8 комисст орж ажилласан. Үүнд: <ol style="list-style-type: none">1. Нийслэлийн Өргөө амаржих газрын хүлээлгийн даевхарт 12.1 м.кв талбайг “Кофе шоп”-ын зориулалтаар,2. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 14-р сургуулийн А байрны 260 м.кв талбайг бага ангийн сурагчдад үйлчлэх “Цайны газар”-ын зориулалтаар,3. Нийслэлийн Ерөнхий боловсролын 168-р сургуулийн 1 даевхарт байрлах 353.5 м.кв	100%

					<p>4. талбайг “Цайны газар”-ын зориулалтаар,</p> <p>5. Нийслэлийн өргөө амаржих газрын байранд байрлах 172.1 м.кв “Цайны газар” -ын зориулалтаар,</p> <p>6. Сонгинохайрхан дүүргийн Нутгийн Захиргааны нэгдсэн байрны 9 дүгээр давхарт 207.63 м.кв талбайг “Цайны газар”-ын зориулалтаар,</p> <p>7. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн 1 давхарт 19.44 м.кв талбайг “Кофе шоп”-ын</p> <p>8. “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-ын 28 м.кв талбайд ажилчдын “Цайны газар”-ын зориулалтаар,</p> <p>9. “ХанУул дүүргийн усан спорт сургалтын төв” ОНӨҮҮТҮГ-ийн харьяа 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах үлчилгээний төвийн 2 давхарт байрлах 65.9 м.кв “Клуб”-ын зориулалтаар,</p> <p>10. Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн төв салбарын байрлах 32.64 м.кв цайны газрын зориулалтаар,</p> <p>11. Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн авто бааз салбарын байрлах 33.8 м.кв цайны газрын зориулалтаар,</p> <p>12. Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн Баянзүрх салбарын байрлах 35.3 м.кв цайны газрын зориулалтаар,</p> <p>13. Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн Хан-Уул салбарын байрлах 40 м.кв цайны газрын зориулалтаар,</p> <p>14. Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн Сонгинохайрхан салбарын байрлах 35.3 м.кв цайны газрын зориулалтаар,</p> <p>15. Нийслэлийн түргэн тусlamжийн төвийн Чингэлтэй салбарын байрлах 27.9 м.кв цайны газрын зориулалтаар,</p> <p>16. “Гэрлэх ёслолын ордон” ОНӨААТҮГ-ын нэгдүгээр давхарт 158.6 м.кв талбайг “Кофе шоп”-ын зориулалтаар,</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>17.“Гэрлэх ёслолын ордон” ОНӨААТҮГ-ын нэгдүгээр давхарт 31.07 м.кв талбайг “Цэцгийн худалдаа”-ын зориулалтаар,</p> <p>18.“Гэрлэх ёслолын ордон” ОНӨААТҮГ-ын нэгдүгээр давхарт 25.5 м.кв талбайг “Хуримын үндэсний хувцасны зөвлөгөө, худалдаа”-ын зориулалтаар,</p> <p>19.Шархадны автобусны эцсийн зогсоолын байрны 2 давхарт байрлах 58.48 м.кв талбайг худалдаа үйлчилгээний зориулалтаар,</p> <p>20.Шархадны автобусны эцсийн зогсоолын байрны 2 давхарт байрлах 24 м.кв зориулалтаар,</p> <p>21.Шархадны автобусны эцсийн зогсоолын байрны 2 давхарт байрлах 14.5 м.кв зориулалтаар,</p> <p>22.Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөөнд байрлах Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн 1 дүгээр давхарт байрлах 7.4 м.кв талбайг “Эмийн сан”-ын зориулалтаар,</p> <p>23.Нийслэлийн Хүрээ амаржих газрын шинэ эмнэлгийн гадна байрлах 288 м.кв талбайг авто машины зогсоолын зориулалтаар,</p> <p>24.Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын “Б” блок байрны 1 давхарт байрлах 40 м.кв талбайг стандартад нийцсэн, шинэлэг, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн бүхий “Сүлжээ дэлгүүр”-ийн зориулалтаар.</p>		
2.14	Арга хэмжээ 2.14 Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын зээл, төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр шинээр бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах, хүлээн авах ажлын хэсэгт орж санал өгөх	-	Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая төгрөг	Барилга байгууламж 187,344.2, тээврийн хэрэгсэл 212,683.4, шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлж бүртгэсэн	НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, YXXXX-ын шийдвэрээр шинээр бий болсон хөрөнгийг тухайн төсөл хэрэгжсэн хуулийн	<p>Тайлант хугацаанд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хандив бэлэглэлийн хөрөнгөөр шинээр бий болсон нийт 151,696,448,965 төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - НИТХ-ын тогтоолоор 32 барилга 98,070,816,933 - Нийслэлийн Засаг даргын захирамжаар 12 тээврийн хэрэгсэл 1,768,066,631 төгрөг - YXXXX-ын шийдвэрээр 5 байгууллагын 48,055,095 - Албан бичиг явуулж бүртгэсэн 120 байгууллагын 49,673,160,313 төгрөг 	100%

				хөрөнгө 41,150.8, YXXXX-ын хурлаар бүртгэсэн хөрөнгө 3,211.0, Бүртгэсэн тушаал ирүүлсэн байгууллагууд ын хөрөнгө 7,137.2	этгээдийн тайлан баланст бүртгэсэн байна.	- <i>Бүртгэсэн тушаал ирүүлсэн 42 байгууллагын 2,136,349,993 төгрөг</i>	
2.15	Арга хэмжээ 2.15 Нийслэлийн өмчit хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлэх	-	Хассан хөрөнгийн дүн, сая төг	Барилга, байгууламж 3,066.3, тээврийн хэрэгсэл 16,067.8, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө 25,501.6 Төрийн өмчид шилжүүлсэн: Барилга 13,430.7, байгууламж 40.5, тээврийн хэрэгсэл 3,876.1, тоног төхөөрөмж 2,366.7	НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, YXXXX-ын шийдвэрээр хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн балансаас хассан байна.	Нийслэлийн өмчit хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй нийт 1,478,768,924 төгрөгийн хөрөнгө акталж данснаас хасах шийдвэр гаргуулж ажилласан. Үүнд: - НИТХ-ын тогтоолоор 14 барилга байгууламж 135,714,197 төгрөг - YXXXX-ын шийдвэрээр 10 байгууллагын 1,343,054,727 төгрөг	100%
2.16	Арга хэмжээ 2.16 Нийслэлийн өмчit хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй балансаас хөрөнгийг баланст	-	Шилжүүлсэн хөрөнгийн дүн, сая төг	Тээврийн хэрэгсэл 734,683.2, тоног төхөөрөмж, тавилга эд	Хуулийн этгээдээс ирүүлсэн хүснэгтийн дагуу НИТХ-ын тогтоол,	Нийслэлийн өмчit хуулийн этгээдийн нийт 30,649,839,067 төгрөгийн өртөг бүхий барилга, тээврийн хэрэгслийг балансаас баланст шилжүүлэх асуудалыг Нийслэлийн Засаг даргад өргөн барьж шийдвэрлүүлсэн. Үүнд: - НИТХ-ын тогтоолоор 2 барилга 21,681,691,628	100%

	шилжүүлэх шийдвэрлүүлэх	асуудлыг		хогшил, биет бус хөрөнгө 25,501.6	Нийслэлийн Засаг даргын захирамж, YXXXX-ын шийдвэрээр хөрөнгийг тухайн хуулийн эттээдийн балансаас хассан байна.	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Засаг даргын захирамжаар 8 тээврийн хэрэгсэл 8,044,732,000 төгрөг - YXXXX-ын шийдвэрээр 10 байгууллагын 923,415,439 төгрөг 	
2.17	Арга хэмжээ 2.17 Хувийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийслэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгч байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авч, ашиглалт хариуцсан байгууллагаад хүлээлгэн өгөх асуудлаар санал боловсруулах, хэрэгжилтийг хангах	-	Хөрөнгийн дүн, сая төг	Шугам сүлжээ 2,481.1	Ашиглалтыг хариуцах байгууллагын баланс бүртгэх асуудлыг өргөн барыж шийдвэрлүүлс эн байна.	НИТХ-ын 2025 оны орон сууцны барилгын инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай 25/58 дугаар тогтоолоор ОСНААУГ ОНӨААТҮГ-ын балансад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй шилжин ирсэн 2,442,061,654 төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилгын шугам сүлжээ, инженерийн байгууламжийг бүртгэсэн.	100%
2.18	Арга хэмжээ 2.18 Төсвийн хөрөнгө оруулалтаар өмнө жилүүд болон 2024 онд бий болсон хөрөнгийн судалгааг ангилал бүрээр гаргах	-	Хөрөнгийн ангилал бурийн дүн, сая төг	Нийслэлийн замын хөгжлийн сан 7,509.1, Нийслэлийн орон нутгийн хөрөнгө оруулалт - 246.1, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 679.4, Улсын төсвийн хөрөнгө оруулалт 3,232.5, Азийн хөгжлийн	Жил бүр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу бий болсон хөрөнгийн бүртгэлийн судалгааг ангилал бүрээр гаргасан байна.	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд бий болсон хөрөнгө. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн орон нутгийн хөрөнгө оруулалт – 17,322,888,763 - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 82,558,734,656 - Улсын төсвийн хөрөнгө оруулалт 68,213,676,747 - Байгууллагын хөрөнгө – 2,136,349,993 - Хандив 1,861,124,631 	100%

				банкны санхүүжилт 463.5, Байгууллагын хөрөнгө - 338.6, Хандив 58.3, ДТХО 1,606.8				
2.19	Арга хэмжээ 2.19 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн ажилд захиалагчийн хяналт тавих, захиалагчийн хяналт тавьсан төсөл, арга хэмжээний 5%-ийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх	-	Санхүүжилтийн дүн, сая төгрөг	Захиалагчийн хяналт 120.4	Барьцаа чөлөөлөх 20.7	Эрх шилжүүлсэн ажлын захиалагчийн хяналтыг тавьж хөрөнгө хүлээлгэн ёгч, санхүүжилтийг олгосон байна. Ашиглагч байгууллагын хүснэлтийн дагуу барьцаа хөрөнгө чөлөөлсөн байна.	<p>Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн захиалагчийн ажил ирээгүй байна. Өмнөх жилүүдэд захиалагчийн хяналт тавьсан 2 төсөл, арга хэмжээний 26.6 сая төгрөгийн 5%-ийн барьцаа хөрөнгө чөлөөлсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - НХААГ/202412124 гэрээт Багахангай дүүргийн "Онцгой байдлын газар" 34,9 сая төгрөгийн авто машин УАЗ мөга ХХК-с 5% 1,7 сая төгрөг - Баянгол дүүргийн ЗДТГ-ын ХААА/УТ-22-06 тоот гэрээтэй Хүүхэд залуучуудын хөгжлийн ордны тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаар Зорь бүрээ ХХК-с 497,5 сая барьцаа 5% 24,9 сая төгрөг <p>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгө хүлээж авах дараах ажлын хэсгүүдэд ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - "Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын даргын 2024.12.09 өдрийн А/175 тушаалаар СХД-ийн хороодод иж бүрэн компьютер нийлүүлэх, - Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024.12.16-ны өдрийн А/192 дугаар тушаалаар Төв цэнгэлдэх хүрээлэнд авто зогсоол шинээр байгуулах ажлыг байнгын ашиглалтад хүлээж авах, - Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2024.12.17-ны өдрийн А/290 тушаалаар Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 220/110/35 кВ-ын "Багануур" дэд станцын 110 кВ-ын хувсаарилах 	100%

						<p>байгууламжийн өргөтгөл, 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35 кВ-ын станц, 50 МВт-ын хүчин чадалтай 200 МВт.ц-ийн багтаамж бүхий эрчим хүч хуримтуурын станцын барилга угсралт хүлээн авах,</p> <ul style="list-style-type: none"> - “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын даргын 2025.01.10-ны өдрийн А/189 дүгээр тушаалаар СХД-ийн ЗДТГ-т 88,998,000 төгрөгийн гэрээний дүн бүхий “Төрийн байгууллагуудын цахим тоног, төхөөрөмж”, - “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын даргын 2025.03.12-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар НЗД-ын 2024.12.26-ны өдрийн А/1338 дугаар захирамж, НХААГ/20240102676, НХААГ/20240102677 гэрээний дагуу 100,996,000 төгрөг, 23,788,000 төгрөгийн үнэ бүхий “Эмнэлгийн тоног төхөөрөмж”, - “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны дугаар тушаалаар “Нумт-Өргөө” ХХК-ийн НХААГ/20240102554/ гэрээний дагуу нийлүүлж буй тоног төхөөрөмж - “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны А/95 дугаар тушаалаар байгуулсан “Хөрөнгө худалдан авах” ажлын хэсгийн хуралд санал, дүгнэлтийг өгсэн. 	
2.20	Арга хэмжээ 2.20 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлаар оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Хурлын тоо, Хөрөнгийн үнийн дүн, сая төгрөг	12 Бүртгэх хөрөнгө 3,211.0, Xасах хөрөнгө 25,501.6, Балансаас баланст шилүүлэх хөрөнгө 30,058.3,	24 Хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцэж шийдвэрийг нийслэлийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн байна.	<p>ҮХХХК-ийн 3 удаагийн хурал зохион байгуулан нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой давхардсан тоогоор 109 байгууллагын хөрөнгийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Даевхардсан тоогоор 36 байгууллагын 2,778,392,893.35 төгрөгийн үнэ бүхий гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүдээс хандиеласан, төсөл хөтөлбөрөөр бий болсон тоног төхөөрөмж, тавилга эд хогшил гэх мэт хөрөнгийг бүртгэх, 	100%

				Дахин үнэлсэн хөрөнгө 5,729.9, Данснаас дансанд шилжүүлсэн хөрөнгө 12,291.9		<ul style="list-style-type: none"> - Давхардсан тоогоо 28 байгууллагын 7,853,990,318.48 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг акталь нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах, - Давхардсан тоогоор 31 байгууллагад 9,502,111,545.59 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг балансаас шилжүүлэх, - Нийт 13 байгууллагын элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах 4,509,521,275.88 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэх, - Нийт 1 байгууллагын 34,181,699.96 төгрөгийн хөрөнгө данснаас дансанд шилжүүлэх. 	
2.21	Арга хэмжээ 2.21 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь хөрөнгийн хөдөлгөөнийг мэдээллийн санд баталгаажуулах, нэгтгэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Үндэсний статистикийн хороонд ТӨ болон ТӨХ маягтуудын дагуу мэдээллийг хүргүүлэх	-	Хуулийн этгээд, сангийн тоо, Мэдээллийн сан дахь нийслэлийн өмчийн хөрөнгийн дүн, сая төг	Хуулийн этгээд 877 Сан 45 7.6 их наяд	Хуулийн этгээд 877 Сан 45 -	Нийслэлийн өмчит нийт хуулийн этгээдүүдийн 2024 оны санхүүгийн тайланг нэгтгэн, 889 хуулийн этгээд, 44 сангийн санхүүгийн тайланг хүлээн авч нийт 11,16 их наяд төгрөгийн хөрөнгийн дүнг мэдээллийн нэгдсэн системд оруулсан. Нийслэлийн өмчийн хөрөнгийн дүн 2023 оноос 3.56 их наяд төгрөгөөр буюу 68.6 хувиар нэмэгдсэн байна.	100%
2.22	Арга хэмжээ 2.22 Нийслэлийн өмчөөс нийслэлийн төсвэвт төвлөрүүлэх орлогыг төсвийн нэмэгдүүлэх, орлогын төлөвлөгөөг НИТХ-ын 2024 оны 24/33 дугаар тогтоолын дагуу төсвийн орлогын нэр төрөл бүрээр ханган ажиллах		Орлогын дүн, сая төгрөг, Хэрэгжилтийн хувь	7,492.6 118%	6,752.7 100%	Нийслэлийн Өмчийн харилцааны газраас нийслэлийн төсвийн орлогын хуваарийн дагуу түрээсийн орлого 3,068.9, ангилагдаагүй бусад орлого 150.0 сая , аж ахуй нэгжийн ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 1,533.8 сая төгрөг, гүйцэтгэл өссөн дүнгээр 2025.06.12-ны өдрийн байдлаар 945.2 сая төгрөг төвлөрүүлж биелэлттэй ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Түрээсийн төлөвлөгөө 894,9сая төгрөг, биелэлт 861.7 сая төгрөг, - Ногдол ашгийн төлөвлөгөө , 0.0 сая төгрөг, биелэлт 14.4 сая төгрөг, 	100%

						<ul style="list-style-type: none"> - Актлагдсан хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө 60.0 сая төгрөг, биелэлт 69.1 сая төгрөг. 	
2.23	Арга хэмжээ 2.23 Нийслэлийн Засаг даргын захирамжаар нийслэлийн өмчит хуулийн этгээдийн данснаас хассан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах	-	Тээврийн хэрэгслийн тоо Дүн, сая төгрөг	62 294.0	Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	<p>Нийслэлийн төсөвт 14 байгууллагын 60 тээврийн хэрэгсэл данснаас хасах хүсэлтийг судалж НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам"-ын дагуу баримтыг бүрдүүлэн өргөн барьж Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/645 дугаар "Тээврийн хэрэгсэл данснаас хасах тухай" захирамжаар шийдвэрлүүлсэн.</p> <p>Нээлтэй дуудлага худалдаагаар худалдах тээврийн хэрэгслийдийг судлахад:</p> <ul style="list-style-type: none"> - 37-19 УНӨ улсын дугаарын мэдээлэл 37-19 УБӨ гэж андуурагдсан 1 тээврийн хэрэгсэл, - Үзлэг, оношилгоонд хамрагдаагүй 29 тээврийн хэрэгсэл, - Авто тээврийн үндэсний төвийн цахим бүртгэлд бүртгэлгүй 5 тээврийн хэрэгсэл, - Нийт 6 тээврийн хэрэгсэл 1,563,714 төгрөгийн татварын өртэй, - Нийт 15 тээврийн хэрэгсэл 2,367,800 тorgууль төлөөгүй, - Бүртгэл болон татвар, тorgуулийн зөрчилгүй 2 тээврийн хэрэгсэл байна. <p>Захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааны бэлтгэл ажлыг ханган, __ зөрчилтэй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлсэн.</p> <p>Цаашид тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлагын худалдааны зар мэдээллийг байгууллагын https://www.umch.ub.gov.mn/news/show/teenvijnheregslijn-neeltje-duudlagyn-hudaldaand-urzh-bajna/mn сайт, өдөр</p>	100%

						тутмын сонинд зар мэдээлэл байршуулахаар бэлтгэн ажиллаж байна.	
2.24	Арга хэмжээ 2.24 Нийслэлийн өмчтэй хуулийн этгээдийн акталж данснаас хассан тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлэх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулах	-	Дүн, сая төгрөг Хэрэгжилтийн хувь	262.8 100%	Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлэх, худалдан борлуулах шийдвэрийн хэрэгжилтийг 100% хангасан байна.	НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан ““Нийслэлийн өмчтэй хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу Нийслэлийн Засаг даргын захирамжаар данснаас хассан тээврийн хэрэгсэл, НӨХГ-ын даргын 28 тушаалаар данснаас хассан тавилга, тоног төхөөрөмжийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн худалдан борлуулах ажлыг зохион байгуулж 2025.06.12-ны өдрийн байдлаар 69.1 сая төгрөгийн орлогыг нийслэлийн төрийн санд төвлөрүүлсэн.	100%
2.25	Арга хэмжээ 2.25 Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох	-	Шүүхийн маргааны тоо, Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо	3 0	3 -	НИТХ-ыг төлөөлөн оролцсон 2 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн. Үүнд: 1.Нэхэмжлэгч: “Анома” ХХК, Хариуцагч: НИТХ, НӨХГ Тус маргааныг ЧД-ийн ИХАШШ-ийн 2020.05.26-ны өдрийн 1239 дүгээр шийдвэр, дааж заалдах шатны шүүхийн 2020.09.07-ны 1900 дүгээр магадлал, дээд шүүхийн 2022.09.22-ны өдрийн 0839 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч 2023.09.25-ны өдөр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах хүсэлт гаргасан бөгөөд УДШ-ийн 2023.11.07-ны өдрийн 0059 дүгээр тогтоолоор хүсэлтийг хангахаас татаалзаж шийдвэрлэсэн. Улмаар нэхэмжлэгч Үндсэн хуулийн цэцэд 2024.03.22-ны өдөр гомдол гаргаж, Үндсэн хуулийн цэцээс шийдвэрийг хуулийн дагуу хянан хэлэлцэж, шийдвэрийг иргэнд мэдэгдэх талаар УДШ-д мэдэгдсэн. УДШ-ын 2024.06.18-ны өдрийн Д001/xm2024/00148 тогтоолоор ЧД-ийн ИХАШШ-ийн 2020.05.26-ны өдрийн 181/ШШ2020/01239 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	100%

					<p>Т.О, өмгөөлөгч А.Н, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Б нарын хяналтын журмаар гаргасан гомдолыг хангаж, нэхэмжлэгчийн өмгөөлөгч Л.Х-ын хяналтын журмаар гаргасан гомдолыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн. Улсын дээд шүүхээс дээрх тогтоолыг 2025 оны 02 сарын 24-ний өдрийн 06/613 дугаарт албан бичгээр хүлээн авсан. НИТХ-д 186,747,735.0 төгрөгийг “Анома” ХХК төлөхөөр шийдвэрлэсэн байна.</p> <p>2.Нэхэмжлэгч: “Хар чонот” ХХК, Хариуцагч: НИТХ</p> <p>ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023.04.09-ний өдрийн 1483 дугаар шийдвэрээр НИТХ-аас 1,023,387,350.0 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэгчийн 456,693,650.0 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Нийслэлийн давж заалдах шатны шүүх 2024 оны 06 сарын 21-ний өдрийн 210/МА2024/01284 дугаарт магадлалаар хариуцагчаас 158,231,567.0 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч “Хар чонот” ХХК-д олгож, улдэх 1,321,849,433.0 төгрөгт холбогдох шаардлагыг хэрэгсэхгүй болгож хариуцагчийн давж заалдах гомдолыг зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна. Нэхэмжлэгч тал хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан боловч хүлээн авахаас татгалзсан байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргыг төлөөлөн оролцсон 2 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн. Үүнд:</p> <p>1.Нэхэмжлэгч: “Алаг даага” ХХК, Хариуцагч: Нийслэлийн Засаг дарга</p> <p>Анхан шатны шүүхийн 2022.11.23-ны өдрийн 0173 тогтоолоор нэхэмжлэлийг буцааж шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч нар 2023.01.16-ны өдөр тус шаардлагаар дахин нэхэмжлэл гаргасан.</p>
--	--	--	--	--	--

						<p>Нийслэлийн Засаг даргын А/216 дугаар захирамжийг түдгэлзүүлэх хүсэлт гаргаж Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023.03.15-ны өдрийн 2486 дугаар шүүгчийн захирамжаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх тус шийдвэрийг хэвээр үлдээсэн.</p> <p>"Угалзат дархан" ХХК-аас 2024.01.24-ний өдөр нэхэмжлэлийн шаардлагагаа өөрчилсөн тул анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байх хугацаанд нэхэмжлэгчид нэхэмжлэлийн шаардлагагаас татгалзсанаар хэрэг хаагдсан байна.</p> <p>2.Нэхэмжлэгч: "ЭХБҮТ" ХХК, Хариуцагч: Нийслэлийн Засаг дарга</p> <p>ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024.09.18-ны өдрийн Д182/шиш2024/03832 шийдвэрээр "ЭХБҮТ"-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв. НИХ-ийн ДЗШШүүхийн 2024.11.22-ны өдрийн 210/МА2024/02008 дугаар магадлалаар ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн Д182/ШШ2024/03832 шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдолыг хангахгүй орхисон байна. Нэхэмжлэгч Хяналтын шатанд гомдол гаргаагүй хэрэг хаагдсан байна.</p>	
2.26	Арга хэмжээ 2.26 Нийслэлийн өмчид хохирол учруулсан, үрэгдүүлсэн, шамшигдуулсан, гэрээний заалтыг зөрчсөн зэрэг өмч хөрөнгийн холбогдолтой асуудлыг хяналт шалгалтын байгууллагаар шийдвэрлүүлэх, шүүхийн	-	Хөрөнгийн маргааны тоо, Дүн, сая төг	16 2,046.5	15 1,922.2	<p>НӨХГ-ын баланс түрүүлж бүртгэлтэй 14 объекттой холбоотойгоор өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлж, хууль бус байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар Нийслэлийн Прокурорын газарт 2024 онд гаргасан хүсэлтийг авлигын эсрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байдлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн ажилласан.</p> <p>1. Нийслэлийн прокурорын тогтоолоор дараах үндэслэлээр хаасан хэрэг:</p>	100%

	маргаанд нэхэмжлэгчээр оролцох,			<ul style="list-style-type: none"> - МБШШТ-ийн тэргүүн С.Санждорж нь СБД, 18-р хороо, Дамбадаржайлин хийдийн Цогчин дуганы барилгыг чөлөөлж, хүлээлгэн өгөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд АТГ-ын №240200420 хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хэргийг хаах саналыг Нийслэлийн Прокурорт хүргүүлэн, прокурорын 2024.12.20-ны өдрийн Д392 тогтоолоор “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” үндэслэлээр хаасан; - ХУД, 3 дугаар хороо “Монгол шуудан” ХК-ийн 36 дугаар салбарын байрыг нийслэлийн өмчийн газрын балансаас ямар нэг шийдвэргүйгээр хасагдсан байгаа нь холбогдох хууль, журам зөрчсөн байдалд АТГ-ын 240200421 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулан, хэрэг хаах тухай саналыг Нийслэлийн прокурорт хүргүүлсэн. Прокурорын 2025.01.20-ны өдрийн Д19 тогтоолоор “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хаасан; - БГД-ийн 7-р хороо, хуучнаар “Эрхэм жаргалан” ΘЭМТ-ийн барилга, 14-р хороо Москва рестораны баруун талд байрлах объектыг тус тус “Тэмүүжин групп” ХХК-д эзэмшиүүлж ашигуулсан, давхар түрээсэлж ашиг олсон үйлдэлд АТГ-ын 240200423 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хэргийг хаах тухай саналыг Нийслэлийн прокурорт хүргүүлсэн. Прокурорын 2025.01.27-ны өдрийн Д24 тогтоолоор “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хаасан; - СБД-ийн 2 дугаар хороо, 1а байрны 1 тоотод байрлах байрыг “Ачит гар” ΘЭМТ хийц бүтээцийг зөвшөөрөлгүй өөрчилсөн, байр чөлөөлөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд АТГ-ын 240200443 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хэргийг хаах саналыг Нийслэлийн прокурорт хүргүүлсэн. Прокурорын 2025.02.07-ны өдрийн Д34 тогтоолоор “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хаасан;
--	---------------------------------	--	--	--

						<ul style="list-style-type: none"> - Ерөнхий сайд Жигжиджавын байранд "Монгол Улсын Нутгийн удирдлагуудын холбоо" ТББ гэрээгүйгээр үйл ажиллагаа явуулдаг асуудалд АТГ 240200427 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хэргийг хаах тухай саналыг прокурорт ирүүлсэн. Прокурорын 2025.02.07-ны өдрийн ДЗ6 тогтоолоор "гэмт хэргийн шинжгүй" үндэслэлээр хаасан. <p>2. Мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэг:</p> <ul style="list-style-type: none"> - УАУЭСКТ-ийг Ж.Хатанбаатарт менежментийн гэрээгээр хувьчлахаар гэрээ байгуулж, үйл ажиллагаа явуулсан, нийслэлийн өмчүүдийг эзэмшигээс асуудал; - СБД, 7-р хороо, 11-р хороолол, 6-р байр, 2-р орц 40 тоот орон сууцыг иргэн С.Жамъянжавын өмчлөлд хувьчилсан, бэлэглэх гэрээгээр иргэн Ш.Дашжамц, Ш.Базарааны нарын өмчлөлд шилжсэн; - СХД, 20-р хороо, Хүнсчидийн гудамжны ЗА, Орбитын орон сууцны дунд байрлах 1 даевхар тоосгон барилгын газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ иргэн С.Батчулууны нэр дээр гарсан; - СХД, дүүрэг, 14-р хороо, 1-р хороолол, 14-8-253 тоот орон сууцыг иргэн О.Сүрэнхорлоо өмчилсөн; - БГД, 14-р хороо, 3 хороолол 18-30 тоот орон сууцыг иргэн П.Цогтбаатарт өмчилсөн; - ЧД, 5-р хороо, "Баруун сэлбэ" үйлчилгээний төвийн барилгын "Ж" блокийн зүүн жигүүрт байрлах 1226.96 м² талбайг "Улаанбаатар радио" ХХК-д эзэмшигээсэн; - "Нью тур сафарис" ХХК-д өр төлбөрт нийслэлийн өмчийн объектуудыг шилжүүлсэн; 	
2.27	Арга хэмжээ 2.27 Өмчийн харилцааны зөрчил маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагад хянан шийдвэрлэхэд	-	Шүүхийн маргааны тоо, Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо	2 -	2 -	<p>НӨХГ-ыг төлөөлэн оролцож хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаа 6 хэрэг байна. Үүнд:</p> <p>1) Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: Б.Ганцогт</p>	100%

төлөөлөн оролцох, шүүхэд тайлбар, холбогдох нотлох баримт гаргаж өгөх, мэдээ тайлан гаргах			<p>ХУД-ийн ИХАШШ-ийн 2021.12.10-ны 2905 дугаар шийдвэрээр түрээсийн гэрээний үүрэгт 25,806,600.0 төгрөг гаргуулж, байрнаас албадан чөлөөлүүлэх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзсан. Давж заалдах шатны 2022.03.18-ны 500 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. ХУД-ийн ИХАШШ-ийн 2022.06.13-ны 1898 дугаар шийдвэрээр үндсэн нэхэмжлэлээс 9,720,000.0 төгрөг, сөрөг нэхэмжлэлийн шаардлагаас 80,000,000.0 төгрөгийг гаргуулахаар шийдвэж, харилцан тооцож нэхэмжлэгчээс 70,280,000.0 төгрөгийг гаргуулан хариуцагчид олгохоор шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүхийн 2022.09.02-ны 1644 дугаар магадлалаар дээрх шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан. ХУД-ийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд 2025 оны 05 сарын 20-ны өдөр шүүх хурал зарлагдсан боловч хариуцагчийн хүсэлтээр 2025 оны 06 сарын 10-ны өдрийг хүртэл шүүх хурлыг хойшиулсан болно.</p> <p>2) Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: "Ачит гар" ТЭМТ 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр "Ачит гар" ТЭМТ нэхэмжлэл гардуулсан. 14 хоногийн дотор шүүхэд хариу тайлбар өгнө гэж Б.Үндраа шүүгчийн туслах Алтантуяагаас 99796002 дугаарт утсаар мэдээлэл авахад шүүхийн ачааллаас хамааран шүүх хурал 2025 оны 08 сард товлогдох талаар хариу өгсөн.</p> <p>3) Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: Г.Алтантуяа Түрээслэгч Г.Алтантуяа нь 2024 онд НӨХГ-тай байгуулсан Нийслэлийн өмчтэй хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээний</p>
--	--	--	---

					<p>төлбөр болох 5,588,100.0 төгрөгийн төлөлтийг хийгээгүй тул тус түрээсийн үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд гаргасан болно.</p> <p>4) Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: "Хоёр сайхан хайрхан" ХХК 2024 онд НӨХГ-тай Нийслэлийн өмчтэй хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан "Хоёр сайхан хайрхан" ХХК нь нийт төлөх ёстой байсан түрээсийн төлбөрөөс 1,026,000.0 төргөг төлбөрийг дутуу төлсөн байх тул Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан болно.</p> <p>5) Нэхэмжлэгч: "Материал Импекс" ХК, Хариуцагч: НӨХГ Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. 2024 оны 01 сарын 23-ны өдрийн 181/ШЗ2024/02086 дугаарт захирамжаар хариуцагчаас нотлох баримт гаргуулах зэргээр хойшлуулсан. Нотлох баримтыг 2024 оны 02 сарын 15-ны өдрийн 1/255 албан бичгээр хүргүүлсэн. Одоогоор шүүх хуралдааны төв зарлагдаагүй байна.</p> <p>6) Нэхэмжлэгч: "Улаанбаатар Радио" ХХК, Хариуцагч: НӨХГ 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр иргэний хэрэг уусэж, 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхээс ирүүлсэн мэдэгдэх хуудсаар "Улаанбаатар радио" ХХК нэхэмжлэлтэй, НӨХГ-т холбогдох иргэний хэргийн шүүх хуралдаан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр төвлөгдсон боловч 2025 оны 05 сарын 22-</p>
--	--	--	--	--	---

						ны өдөр нэхэмжлэгч "Улаанбаатар Radio" ХХК-ийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан хүсэлтийг иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд гаргасан байна.	
2.28	Арга хэмжээ 2.28 Нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргааныг зохицуулах, шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Х.Батчимэг, прокурор Б.Болортuya нартай уулзалт хийж, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдээс үлдэгдэл төлбөрийг нэхэмжлэх, шүүхэд үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргах ажлуудыг шат дараалан хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллан, тэр нийтийн ашиг сонирхлыг хамгаалж өгөхийг хүссэн 1/765 дугаар албан бичгийг 2025.05.13-ны өдөр хүргүүлэн ажилласан. Энэхүү ажлын үр дүнд нийслэлийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх ач холбогдолтой юм.</p> <p>Нийслэлийн өмч эзэмшигч дүүргийн ИХТ, НЗДТГ, Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ, ерөнхий боловсролын дунд сургуулийн илүүдэлтэй байр талбай, түрээсийн цайны газрын байр, талбайн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийн, цаашид үүсэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хүргэсэн.</p>	100%
2.29	Арга хэмжээ 2.29 Холбогдох хууль тогтоомжийн төсөлд санал оруулах, өмчтэй холбоотой хууль, дүрэм, журмыг сурталчлан, арга зүйгээр хангах	-	Саналын тоо Хэрэгжилтийн хувь	"Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" -т 4 арга хэмжээ, Нийслэлийн хөгжлийн 2025 оны	100%	<p>НЗДТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу дараах хууль, журмын төсөлд санал хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, - Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам, - Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн мөнежментийн тухай хууль - Худалдан авах ажиллагааны тухай хууль - Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль - Арилжааны тухай хууль 	100%

			төлөвлөгөө"- ний төсөлд тусган З арга хэмжээ, хуулийн төсөл 1		- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай, Иргэний болон захирагааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль - Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль - Нийтийн өмчийн тухай хууль, - Дулаан хангамжийн тухай хууль	
2.30	Арга хэмжээ 2.30 НИТХ-ын тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдан нийслэлийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа нийслэлийн өмчийн эрх зүйн акт, дүрэм, тогтоол, журмуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд НИТХТ-ийн 2014 онд батлагдсан журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам", "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам", "Нийслэлийн өмчимт үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам", - НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийг эзэмшиүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам", "Нийслэлийн өмчийг эзэмшиүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар", - НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам", "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам", Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ", "Нийслэлийн өмчимт хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ", - НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчимт хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам", "Нийслэлийн өмчийг хувьчлах журам",

						<ul style="list-style-type: none"> - НИТХТ-ийн 2014 оны 67 дугаар тогтоолоор баталсан „Нийслэлийн өмч хувьчлах комиссын ажиллах журам”, - НИТХТ-ийн 2014 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшилийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам”. <p>“Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай” хуулийн төсөл, “Нийтийн өмчийн тухай” хуулийн төсөлд санал хүргүүлэн, шинэчлэгдсэн хуулиуд батлагдсаны дараа нийслэлийн өмчтэй холбоотой мөрдөж буй журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж өргөн барихаар ажиллаж байна.</p>	
2.31	Арга хэмжээ 2.31 Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”, 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ын дагуу нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - НӨХГ-ын даргын 2024.12.31-ний өдрийн А/798 дугаар тушаалаар б дүүргийн 112 барилгын сул буюу илүүдэлтэй байр талбай, түрээсийн гэрээний хэрэгжилт, - НӨХГ-ын даргын 2025 оны А/40 дүгээр тушаалаар б дүүргийн 201 барилга байгууламж, Эрүүл мэндийн төв, ΘЭМТ-дийн байр ашиглалт, түрээсийн гэрээний хэрэгжилт, төлбөр төлөлгүй нийслэлийн өмчийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн 	100%

					<p>этгээдийг олж тогтоох, гэрээ байгуулахыг даалгах, байр талбайг чөлөөлүүлэх, түрээсийн төлбөрийг нийслэлийн төсөөт төвлөрүүлсэн эсэхийг газар дээр нь шалгаж, зөрчлийг арилгах зөвлөмж өгч ажилласан./Ажлын хэсгийн тайланг хавсаргав./</p> <ul style="list-style-type: none"> - НӨХГ-ын даргын 2025 оны А/62 удирдамжийн дагуу б дүүргийн ЗДТГ,ИХ, Боловсролын нийт 215 байгууллагад газар дээр нь очиж үзэн, хяналт шалгалтыг хийж, түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж байгаа байр талбайд хяналтын хэмжилт хийх, барилгын дээвэр дээр үүрэн телефоны станц антен, байр талбайд бэлэн мөнгөний ATM, киоск машинуудыг байршуулсан эсэхэд хяналт шалгалт хийн зөвлөмж өгч ажилласан. ./Ажлын хэсгийн тайланг хавсаргав./ <p>Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Төр Захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн харьяа 4 байгууллагын байр ашиглалт, Ашигтт малтмалын газрын Цөмийн болон цацрагийн хэлтэс, БГД-т байрлах МШ-ийн 24-р салбарын гар утасны түрээслэгчид, Ачит гар ӨЭМТ-д байр талбай чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүлсэн, - СХД-н Цагдаагийн гуравдугаар хэлтэст “Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв”-ийн холбогдох баримт бичгийн хуулбар, лавлагагааг нотлох баримтын шаардлагыг хангуйж хүргүүлсэн. - Соёлын Төв өргөөний Г блокд байрлах нийслэлийн харьяа 6 байгууллага, 24 иргэн, аж ахуй нэгжийн 150 гаруй өрөө үйл ажиллагаа явуулж байснаас 30 иргэн аж ахуй нэгжид байр талбай чөлөөлөх тухай мэдэгдэх хуудсыг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 01 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд хүргүүлж, сул байр
--	--	--	--	--	---

					<ul style="list-style-type: none"> - талбайн ашиглалтыг илтгэх хуудсаар танилцуулсан, - СБД-ийн 11 дүгээр хорооны Барилгачидын гудамжид барилгын хашаан дотор 2012, 2013 байршуулсан сурталчилгааны самбарын талаар хорооны ажилтан, барилга барихаар төлөвлөсөн компаниас мэдээллийг авч удирдлагад танилцуулсан, - “Уламжлалт анааах ухааны элэг судлалын клиник төв”-ийн СХД-т байрлах эмнэлэг, ХУД-т байрлах “Богд уул” Сувилалын хөрөнгийг СХД-ийн Нэгдсэн эмнэлгийн баг бүрэлдэхүүнтэй хамтран газар дээр нь очиж, хөрөнгийг тоолж, хүлээлцүүлсэн, - СТӨ-ны 8 дугаар давхрын 2 өрөө, Хүүхдийн номын сангийн 1 давхрын 1 өрөөг ашиглаж байсан “Сөүлийн соёл мэдээллийн төв”-ийн байр талбайг чөлөөлүүлэн, үйл ажиллагаандaa ашиглаж байсан гэх таөвилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэх, ашиглах боломжгүй талаар НЭДТГ-т албан бичгийг хүргүүлсэн, - Таван толгой түлш ХХК-д НӨХГ-ийн эзэмшил газарт шахмал түлшний агуулахын зориулалтаар баригдсан 59 саравчийг нийслэлийн өмчид бүртгэх, цаашид ашиглах боломжгүй, ашиглаж байсан газрын төлбөр тооцоог барагдуулан, газрыг чөлөөлж, манай байгууллагад хүлээлгэн өгөх тухай албан бичгийг хүргүүлсэн, - 9 дүүргийн харьяа нийслэлийн өмчимт хуулийн этгээдүүдийн ашиглалтын шаардлага хангахгүй байгаа барилга байгууламжуудын судалгааг авч нэгтгэн, газрын даргад танилцуулсан, - НӨХГ-ын даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг Улаанбаатар радио”ХХК-ийн эзэмшиж байсан 	
--	--	--	--	--	---	--

						<ul style="list-style-type: none"> - Баруун сэлбэ үйлчилгээний төвийн “Ж” блокийн барилгыг акт үйлдэн хүлээн авсан, - Нийслэлийн Төр Захиргааны 5 дугаар байранд байрлах нийслэлийн харьяа 4 байгууллагын байр ашиглалт, Ашигт малтмалын газрын Цөмийн болон цацрагийн хэлтэс, БГД-т байрлах МШ-ийн 24-р салбарын гар утасны түрээслэгчид, Ачит гар ӨЭМТ-д байр талбай чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүлсэн. 	
--	--	--	--	--	--	---	--

Зорилго 3. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх

3	Зорилт 3. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна.					
3.1	Арга хэмжээ 3.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж хяналт шинжилгээ үнэлгээ хийж НЭДТ-т тайлганах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>НЭДТГ-аас ирсэн үүрэг даалгаврын дагуу дараах бодлогын баримт бичгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02,03 дугаар албан даалгавар хэрэгжүүлэх төлөвлөгөө (7 арга хэмжээ), - Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2025 онд байгуулсан “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний төлөвлөгөө (25 арга хэмжээ), - Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл; <p>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг НЭДТГ-т хугацаанд нь хүргүүлж тайлгнасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтийн 2015-2025 оны явцын тайлан мэдээ (7 ажил),

				<ul style="list-style-type: none"> - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан (30 заалт), - Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны №1 албан даалгааврын төлөвлөгөөний биелэлт (6 арга хэмжээ), - Засгийн газрын 2022-2024 оны тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгааврын хэрэгжилт (6), - Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт (3 шалгуур үзүүлэлт), - “Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний шалгуур үзүүлэлтийн тайлан (4), - Нийслэлийн Засаг даргын 2024 оны 1 болон 3 дугаар Албан даалгааврын хэрэгжилт, - Нийслэлийн Засаг даргын 2024-2025 оны захирамжаар байгуулсан ажлын хэсгийн биелэлт, - Нийслэлийн Засаг даргын 2025 оны захирамжийн биелэлт, - Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хэрэгжилт (19 шийдвэр), - НИТХ-ын 2025 оны 05 дугаар сар хүртэлх тогтоолын биелэлт (22 тогтоол), - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт болон засаг даргатай байгуулсан “Хуульд заасан зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний хэрэгжилтийн мэдээлэл, - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай 2025 онд байгуулсан “Хуульд заасан төрийн зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ”-ний биелэлт. 	
--	--	--	--	---	--

						НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж нийт 162 баримт бичгийг хяналтад авч холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
3.2	Арга хэмжээ 3.2 Хяналт шалгалтын дээд байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах	-	Ирүүлсэн зөвлөмжийн тоо, хэрэгжилтийн хувь	Нийслэлийн Төрийн аудитын зөвлөмж, НЗТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмж, 100%	3 100%	<p>Дээд байгууллагаас ирүүлсэн дараах зөвлөмж, чиглэлийг хэрэгжилтийг ханган хугацаанд нь тайлagnan ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - НЗДТГ-ын 2025 оны 03/2113 дугаар албан бичгээр "Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээ"-г байгууллага дотооддоо үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу НӨХГ-ын даргын 2025.04.22-ны өдрийн А/43 дугаар тушаалаар үнэлгээ зохион байгуулах ажлын хэсгийг нэгжийн удирдлагууд, холбогдох албан хаагчдын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсэг байгууллагын засаг төлөв байдлын үнэлгээг үнэн зөв, бодит мэдээлэл цуглуулан, холбогдох баримтууд, мэдээллийг судалж дүн шинжилгээ хийн, судалгаа, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийн байдалд тулгуурлан www.moontra.com үнэлгээний цахим маягтад 2025.04.25-ны өдөр 126 асуумжийг хамтран хэлэлцэж бөглөсөн болно. Тайланг НЗДТГ-т 2025.04.25-ны өдрийн 1/665 дугаар албан бичгээр хүргүүлсэн. - ТӨБЗГ-ын 2025.05.19-ний өдрийн А-1/963 дугаар албан бичгээр ирүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн өөрийн болон орон нутгийн өмчийт болон орон нутгийн өмчийн оролцоотой 33 хуулийн этгээдүүдийн мэдээллийг нэгтгэн НӨХГ-ын 2025.06.02-ны өдрийн 1/889 албан бичгээр хүргүүлсэн. <p>НЗДТГ-аас ирүүлсэн журам, захирамж, үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэл, гэрээний төсөл зэрэг 18 баримт бичгийг хяналтад авч нийт хэлтэст "танилцуулах",</p>	100%

						"санал авах" хуудсаар үүрэгжүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
3.3	Арга хэмжээ 3.3 нэдтг Монгол Улсын сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнах	-	Ажил, үйлчилгээ, хөрөнгийн дүн, сая төг	-	79	<p>Тайлант хугацаанд НӨХГ-аас худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 2 ОНӨААТҮГ-ын худалдан авах ажиллагаанд гишүүнээр орж ажилласан. Үүнд:</p> <p>Асгат ОНӨААТҮГ-ын "2025 оны БГД-ийн цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер"</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр нийт 27 багцтай 4,487,585,800 төгрөгийн тендерийг зарласан. 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр тендер нээж, давхацсан тоогоор 35 аж ахуй нэгж, хуулийн этгээд материалыаа ирүүлсэн бөгөөд 14 багц шалгарсан байна. 2. Дахин тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны 04 дугаар сарын 18-ны өдөр 13 багцтай 2,849,382,700 төгрөгийн тендерийг зарласан. 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр тендер нээж, давхацсан тоогоор 11 аж ахуй нэгж, хуулийн этгээд материалыаа ирүүлсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр үр дүн нийтэлж 5 багц шалгарсан байна. <p>Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын "2025 оны Сүхбаатар, чингэлтэй дүүргийн цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер"</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 оны худалдан авах төлөвлөгөөнд 	100%

						тусгасан 33 багцтай 7,436,780,950 төгрөгийн тендерийг зарласан 23 багцад 16 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 23 багцад ирүүлсэн тендерийн баримт бичиг хянан, үнэлж үзээд 6 аж ахуйн нэгж байгууллагын 13 багцад гэрээ байгуулах эрх олгож, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй, төсөөвт өртөг хэтэрсэн, нэг ч оролцогч оролцоогүй 22 багцад дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зарлан, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийн, үнэлгээ хийх шатандaa явж байна.	
3.4	Арга хэмжээ 3.4 2025 оны нийслэлийн "Бүтээн байгуулалтын жил"-ийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Нийслэлийн Засаг даргын 2025.01.02-ны өдрийн "2025 оныг "Бүтээн байгуулалтын жил" болгон зарласан тухай А/01 дүгээр захирамжийг хяналтад хүлээн авсан.</p> <p>НЭДТГ-аас 2025.03.28-ны 02-02/1865 дугаартай албан бичгээр ирүүлсэн Нийслэл хотод хэрэгжүүлэх 24 мега төслийн танилцуулгын хүрээнд албан хаагчид болон олон нийтэд үнэн, зөв мэдээллийг үе шаттайгаар танилцуулах төлөвлөгөөг гаргаж, 2025.03.31-ний өдрийн сургалтаар "Түгжрэлийг бууруулах ажил"-ын хүрээнд хийгдэх 10 мега төсөл, 2025.04.07-ны өдрийн сургалтаар "Агаарын бохирдлыг бууруулах" ажлын хүрээнд хийгдэх 6 мега төсөл, 2025.04.11-ний өдрийн сургалтаар "Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх" ажлын хүрээнд хийгдэх 8 мега төслийн танилцуулгыг хийж, тайлант 2025.04.14-ний өдрийн 1/568 дугаарт албан бичгээр Нийслэлийн Засаг Даргын тамгын газарт хүргүүлсэн болно. Мөн сургалт зохион байгуулагчдын зүгээс Мега төслүүдийн танилцуулгын талаар нийт албан хаагчдын дунд сэтгэл ханамжийн судалгааг https://docs.google.com/forms ашиглаж авахад төслийн танилцуулга сургалтын явц, сургалтын материал болон заах аргын талаар нийт сургалтад хамрагдагсад маш сайн үнэлгээгээр дүгнэсэн судалгааны үр дүн гарсан.</p>	100%

						Nийслэлийн зүгээс 2025 оныг "Бүтээн байгуулалтын жил" болгон зарласантай холбоотой 24 мега төслийн талаарх Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны https://ulaanbaatar.mn/home цахим хуудсанд байршуулсан танилцуулгыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/ , FACEBOOK цахим хуудас https://www.facebook.com/umch.ub.gov.mn дамжуулан мэдээллийг олон нийтэд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар хүргүүлсэн.	
3.5	Арга хэмжээ 3.5 Байгууллагын үйл ажиллагаанд MNS ISO 9001:2016 чанаарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	НЭДТГ-аас MN ISO 9001:2016 чанаарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажилд чиглэл ирүүлээгүй байна.	X/Б
3.6	Арга хэмжээ 3.6 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих	-	Модны тоо, Өртөг, сая төг	111	111	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны хаврын "Бүх нийтийн мод тарих", тариалсан мод, бут, сөөгийг арчлан хамгаалах арга хэмжээний хүрээнд НӨХГ-ын хамт олон 05 дугаар сарын 03-ны өдөр Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд 160 хайлаас суулгаж, усалж, арчилснаас гадна өнгөрсөн онуудад суулгаж, ургуулсан мод, бут, сөөгөө усалж арчлах ажлын зохион байгуулсан. Дээрх ажлын мэдээллийг байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/a/411 , https://www.facebook.com/umch.ub.gov.mn/posts/pfbid0LX6tku2HRvKZDUKJj74UQpVEXe9K1oyxHMjhakjzAWrfFnqzCqugJJ5YFWxsLJEEI?rid=5itlbEG91aQltPMS# -т тус тус байршуулан нийтэлж олон нийтэд мэдээлсэн.	100%
3.7	Арга хэмжээ 3.7 Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг ажиллуулж байгууллагын	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн нэгдүгээр хуралдаанаар байгууллагын баланст бүртгэлтэй ХУД-ийн Туул тосгонд байрлах "Хар үнэгний аж ахуйн"-ийн барилга, байгууламжийг Нийслэлийн Мал эмнэлгийн	100%

	эд хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөрөнгийн захиран зарцуулалтад хяналт тавих					газрын, ХУД-ийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Буянт Ухаа 1” 30 айлын орон сууцыг Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн баланст шилжүүлэх асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэсэн.	
4	Зорилт 4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг бүрэн хангана.						
4.1	Арга хэмжээ 4.1 НЭДТГ Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 26, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх” ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж ажилласан.	100%
4.2	Арга хэмжээ 4.2 НЭДТГ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тус хөтөлбөрийн хамаарах заалтыг тусган нийт 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг НЭДТГ-т 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлэхээр тайланг бэлтгэн ажиллаж байна.	100%
4.3	Арга хэмжээ 4.3 Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө мэдээлэл өгөх, авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах	-	ХАСХОМ, ХАСУМ мэдүүлэг бөглөсөн албан хаагчдын тоо	ХАСХОМ 34 ХАСУМ 17	ХАСХОМ 9 ХАСУМ –	Тайлант онд 8 албан хаагчийн ХАСХОМ, 6 иргэний ХАСУМ-ыг хуульд заасан хугацаанд гаргуулж, хянуулсан. Мөн Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2025.01.15-ны өдөр зохион байгуулсан “Мэдүүлэг гаргагчдад зориулсан сургалт”-д 7 албан хаагчийг, 2025.01.06-ны өдөр зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, эрх бүхий албан тушаалтнуудын сургалт”-д 1 албан хаагчийг тус тус хамруулсан.	100%

5	Зорилт 5. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.					
5.1	Арга хэмжээ 5.1 нэдтг Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах сургалтад 2025.02.07-ны өдөр ёс зүйн дэд хорооны 5 гишүүнийг, “Бүсчилсэн хөгжил- Төрийн албаны манлайлал” нийслэлийн бусийн төрийн албан хаагчдын зөвлөгөөнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ” хэлэлцүүлэгт 2025.05.28-29-ний өдрүүдэд Ёс зүйн дэд хорооны гишүүнийг тус тус хамруулсан. Мен сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөлөөр ханган байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлж Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг сурталчлан танилцах цэсийг бий болгосон ба сургалт зохион байгуулах өрөөгөөр ханган ажилласан.</p>
5.2	Арга хэмжээ 5.2 нэдтг Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор “Төрийн захирагааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ” шинэчлэн баталж байгууллагын Ёс зүйн дэд хороо албан хаагчдад мэдээлэл хүргэн, танхмын сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Нийт албан хаагчдад Засгийн газрын тогтоол, хавсралт, сургалтын материалыг ERP систем НӨХГ-ын бүлэг, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулсан.</p>
5.3	Арга хэмжээ 5.3 нэдтг Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, дүрмийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээлэх, байгууллага ёс зүй, шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төрлийг тодорхойлох чиглэлээр хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангахаар ажиллаж байна.</p>

						Байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээний фэйсбуук пэйжээр дамжуулан дараах https://www.umch.ub.gov.mn/a/295 , https://www.facebook.com/share/p/1B2apHm1W8/ холбоосор Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн танилцуулгыг нийтэлсэн.	
6	Зорилт 6. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл технологийг сайжруулна.						
6.1	Арга хэмжээ 6.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын жилийн төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	32 100%	32 100%	<p>Байгууллагын цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/, олон нийтийн сүлжээний фэйсбуук платформ https://www.facebook.com/umch.ub.gov.mn -д байгууллагын үйл ажиллагааг нийтэд мэдээлэн баяжилтыг тухай бурд хийж ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын төвч танилцуулга болон газрын дарга, хэлтэс нэгжүүдийн танилцуулга https://www.umch.ub.gov.mn/p/170 https://www.umch.ub.gov.mn/p/168, - Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги зорилтууд, бүтэц зохион байгуулалт https://www.umch.ub.gov.mn/p/2 https://www.umch.ub.gov.mn/p/14 - Байгууллагын албан хаагчдын мэдээлэл, өрөөний дугаар, холбоо барих утас болон цахим шуудангийн хаяг https://www.umch.ub.gov.mn/p/c/26 - Байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл https://www.umch.ub.gov.mn/p/173 - Төсөв, санхүүгийн мэдээлэл https://shilendans.gov.mn/organization/11573?ry=2025&group=117, - Байгууллагын мөрдэж буй хууль тогтоомж, дүрэм, журам болон 2024, 2025 оны Нийслэлийн Засаг даргын захирамжууд, НИТХ тогтоолууд, Өмчийн харилцааны газрын даргын тушаалууд https://www.umch.ub.gov.mn/p/61, 	100%

					<ul style="list-style-type: none"> - <u>https://www.umch.ub.gov.mn/p/189</u>, <u>https://www.umch.ub.gov.mn/p/185</u> - Уйл ажиллагааны ил тод байдал буюу үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, үйл ажиллагааны статистик мэдээ, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайлан болон Нийслэлийн өмчийн оролцоотой ХК, ХХК, ОНӨААТҮГ-ын мэдээлэл <u>https://www.umch.ub.gov.mn/p/c/30</u>, <u>https://www.umch.ub.gov.mn/p/c/23</u>, <u>https://www.umch.ub.gov.mn/p/c/27</u> - Хүний нөөцийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, хэрэгжилт, Ёс зүйн дэд хорооны мэдээлэл, сүл орон тооны мэдээлэл, албан тушаалын тодорхойлолт, цалин хөлс, урамшууллын хэмжээний талаар <u>https://www.umch.ub.gov.mn/p/c/24</u> <u>https://www.umch.ub.gov.mn/p/c/29</u> <u>https://www.umch.ub.gov.mn/p/c/18</u>, <p>Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд байгууллагын шилэн дансанд “Төсөв, гүйцэтгэл”, “хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт”, “бусад” зэрэг нийт 42 мэдээллийг байршуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө <u>https://www.umch.ub.gov.mn/p/c/5</u>, - Сонгон шалгаруулалтын зар мэдээ <u>https://www.umch.ub.gov.mn/as/selection</u>, - Дуудлага худалдааны зар мэдээ <u>https://www.umch.ub.gov.mn/as/auction</u>, - Цаг үеийн мэдээ, мэдээлэл <u>https://www.umch.ub.gov.mn/as/news/1</u>, - Байгууллагын мэдээ, мэдээлэл <u>https://www.umch.ub.gov.mn/as/news/3</u>, - Фото мэдээ <u>https://www.umch.ub.gov.mn/as/news/2</u>.
--	--	--	--	--	---

						НӨХГ цахим хуудас, фэйсбуүк пэйж хуудсаар дамжуулан байгууллагын үйл ажиллагааны дотоодын болон гадагшаа чиглэсэн мэдээ мэдээлэл, НЭДТГ-ын Улаанбаатар мэдээ болон https://www.ulaanbaatar.mn/ цахим хуудасны мэдээ мэдээлэл, бусад нийслэлийн харьяа агентлаг, ННЗБ-ын онцлох мэдээ мэдээллийг өдөр бүр нийтэлж байна. 2025 оны хагас жилийн байдлаар сайтад байгууллагатай холбоотой мэдээ мэдээлэл-37 , турээслэгч сонгон шалгаруулах зар-41, өмчийн дуудлага худалдааны зар-4, түүнчлэн Нийслэл, ННЗБ-ын онцлох мэдээ мэдээлэл буюу цаг үеийн 150 гаруй мэдээ мэдээлэл нийтлэгдсэн.	
6.2	Арга хэмжээ 6.2 Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст захирамжлахын баримтуудын баяжилтыг хийх	-	Оруулсан тушаалын тоо	500	500	“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой 86 газрын даргын “A” тушаалыг Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст бүртгэн, төрийн байгууллагууд болон олон нийт танилцах боломжоор ханган ажилласан.	100%
6.3	Арга хэмжээ 6.3 Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг UBERP-ийн Дотоод удирдлагын хяналт-шинжилгээ үнэлгээ цэс байршуулж тайлагнах	-	Үүрэг даалгаврын тоо, гүйцэтгэлийн хувь	65 100%	- 100%	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2025 оны 14 удаагийн хуралдааны 54 үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн, ERP системд хугацаанд нь оруулан тайлагнасан. Үүнд: 1) 2024.12.30-ны өдрийн 2 үүрэг даалгавар, 2) 2025.01.13-ны өдрийн 12 үүрэг даалгавар 3) 2025.01.27-ны өдрийн 5 үүрэг даалгавар 4) 2025.01.31-ний өдрийн 5 үүрэг даалгавар 5) 2025.02.03-ны өдрийн 3 үүрэг даалгавар 6) 2025.02.07-ны өдрийн 3 үүрэг даалгавар 7) 2025.02.10-ны өдрийн 3 үүрэг даалгавар 8) 2025.03.06-ны өдрийн 2 үүрэг даалгавар 9) 2025.03.17-ны өдрийн 2 үүрэг даалгавар 10) 2025.03.31-ний өдрийн 2 үүрэг даалгавар 11) 2025.04.14-ний өдрийн 4 үүрэг даалгавар 12) 2025.04.29-ний өдрийн 6 үүрэг даалгавар 13) 2025.05.12-ны өдрийн 1 үүрэг даалгавар 14) 2025.06.09-ны өдрийн 4 үүрэг даалгавар	100%

7	Зорилт 7. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.						
7.1	Арга хэмжээ 7.1 Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох зэрэг хүний нөөцийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/980 дугаар захирамжийн дагуу батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан нийт 49 албан хаагч (хүүхэд асрах чөлөөтэй 3) ажиллаж байна.</p> <p>Байгууллагад бүтээлтэй ажилласан 6 албан хаагчийг НИТХ, Нийслэлийн Засаг даргын шагналд тодорхойлон шагнаж урамшуулсан.</p> <p>Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг зөрчсөн 3 албан хаагчид сахилгын шийтгэл ноогдуулсан.</p>	100%
7.2	Арга хэмжээ 7.2 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар төлөвлөн ажиллах, тайлагнах	-	Арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	13 100%	13 100%	<p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батал, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - НӨХГ-ын даргын 2024 оны А/16 дугаар тушаалаар албан хаагчдад олгох хоол, унааны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн баталж, нийт албан хаагчдад сар бүр олгосон, - Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/578 дүгээр захирамж, НӨХГ-ийн даргын 2025 оны Б/42 дугаар тушаалаар 8 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан, 1 албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн олгож, цалин хөлсийг нэмэгдүүлсэн, - Нийт албан хаагчдын ажилласан жилийг хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, цахим лавлаггаатай тулгаж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг сар бүр бүрэн олгосон, - НӨХГ-ийн даргын 2025 оны Б/15 тушаалаар 1 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж болон цалинтай чөлөө олгосон. 	100%
7.3	Арга хэмжээ 7.3 Байгууллагын албан хаагчдын хөтөлбөрийг сургалтын батлуулж,	-	Арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	24 сургалт 100%	24 сургалт 100%	Байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөө баталж, Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтад 8, бусад байгууллагаас зохион	100%

	хэрэгжилтийг ажиллах	ханган				байгуулсан 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 76 албан хаагчдыг хамруулсан. Үүнд:	
						<ul style="list-style-type: none"> - Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалтад 2025.01.06-ны өдөр 1 албан хаагч, - Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн төрийн албан хаагчийн оролцоо модуль, дэд системүүдийг танилцуулах сургалтад 2025.01.31-ний өдөр 1 албан хаагч, - Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах сургалтад 2025.02.07-ны өдөр ёс зүйн дэд хорооны 5 гишүүн, - Орон нутгийн өмчийн газрын бүртгэл, ашиглалт хариуцсан албан хаагчдад зорилсан сургалтад 2025.02.10-11-ний өдрүүдэд 8 албан хаагч, - Албан хэргийг хос бичгээр хөтлөх архивын нэжг бүрдүүлэх сургалтад 2025.02.12-ны өдөр 7 албан хаагч, - Байгууллагын зэрэг соёлыг бүрдүүлэх нь сэдэвт сургалтад 2025.03.13-14-ний өдрүүдэд 4 албан хаагч, - ННЗБ-уудын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад 2025.03.25-ны өдөр 1 албан хаагч, - Нээлттэй мэдээллийн shilen.gov.mn системд байршуулсан шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, хянан баталгаажуулах сургалтад 2025.03.25-ны өдөр 1 албан хаагч, - Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ сэдэвт сургалтад 2025.03.26-ны өдөр 28 албан хаагч, - Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалтад 2025.04.18-ны өдөр 4 албан хаагч, 	

						<ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн 2025 оны тайлан, мэдээ нэгтгэл сэдэвет сургалтад 2025.05.05-09-ний өдрүүдэд 10 албан хаагч, - Ахмадын туршилага байгууллагын хөгжилд хэлэлцүүлэгт 2025.5.25-ны өдөр 2 албан хаагч, - ННЗБ-уудын төрийн албананд шинээр томилогдсон албан хаагчдыг зөвлөн чиглүүлэх менторшип хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан сургалтад 2025.05.05-07-ны өдрүүдэд 3 албан хаагч, - “Бүсчилсэн хөгжил- Төрийн албаны манлайлал” нийслэлийн бусийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн хэлэлцүүлэгт 2025.05.28-29-ний өдрүүдэд 3 албан хаагчийг тус тус хамруулсан. 	
7.4	Арга хэмжээ 7.4 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд 5 албан хаагчид хүүхэд асрах чөлөө, 2 албан хаагчид жирэмсний болон амаржсаны амралт олгон, хүүхэд асрах чөлөө дуусгавар болсон 1 албан хаагчийг томилон ажиллуулсан.</p> <p>“Жендерт сууринсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдэж, албан хаагчдад болон иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.</p>	100%
7.5	Арга хэмжээ 7.5 Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, Хариуцлагын гэрээ, төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагад тайлагнах, нэгж, албан хаагчдын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн	-	Нэгж, албан хаагчдын тоо, Гүйцэтгэлийн хувь	4 нэгж 22 төрийн захиргааны, 6 төрийн үйлчилгээний албан хаагч 100%	4 нэгж 22 төрийн захиргааны, 6 төрийн үйлчилгээний албан хаагч 100%	<p>1.Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хариуцлагын гэрээг 2025.01.02-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 58 арга хэмжээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бодлогын зорилтын 2 арга хэмжээ, - Хуулиар тусгайлан олгогдсон чиг үүрэг 31 арга хэмжээ, - Хуулиар нийтлэг олгогдсон чиг үүрэг 24 арга хэмжээ, - Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлийн 3 арга хэмжээ 	100%

	гэрээг хугацаанд нь баталгаажуулах, тайлагнах					<p>2. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ыг мөрдлөг болгон ажиллаж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ бүрийг нэгжийн төлөвлөгөөнд тусгуулан 4 нэгжийн дарга, 22 төрийн захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, 6 төрийн үйлчилгээний албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.</p> <p>3. Төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой 19 албан хаагч, бүтэц, орон тоо өөрчлөгдсэнтэй холбоотой 6 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.</p> <p>4. Төрийн захиргааны 26 албан хаагчийн батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг хувийн хэрэгт хавсаргасан. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг нийт албан хаагчдад танилцуулж, хувийн хэргийн бүрдүүлбэрийг бүрэн хангаж нийт 51 албан хаагчийн хувийн хэргийг цаасан суурьтайгаар мэн ХНУМТ программд цахим хэлбэрээр бүрдүүлж, холбогдох бүртгэлийг хөтөлсөн. Дээрх цахим бүртгэлээс үндэслэн E-Mongolia-аар дамжуулан төрийн албад ажиллаж байгаа болон цалингийн тодорхойлолтыг цахимаар авах боломжтой болсон.</p>	
8	Зорилт 8. Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан, ил тод байдлыг ханган ажиллана.						
8.1	Арга хэмжээ 8.1 Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын дагуу шилэн дансны мэдээллийг https://shilendans.gov.mn/	-	Мэдээллийн тоо, Хэрэгжилтийн хувь	159 100%	159 100%	<p>Тайлант 2025.06.06-ны өдрийн байдлаар Шилэн дансанд нийт 77 мэдээллийг бүрэн үнэн зөв, бодитой, иж бүрэн байршуулсан. Төрлөөр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - Төсвийн гүйцэтгэлийн 20 мэдээлэл - Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 54 мэдээлэл, - Бусад 3 мэдээлэл <p>"Шил ажиллагаа" цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны 29 мэдээ, мэдээллийг үнэн зөв нийтэлж,</p>	100%

	цахим системд цаг хугацаанд нь байршуулах					холбогдох мэдээллийн цахим системүүдэд байршуулсан.	
8.2	Арга хэмжээ 8.2 Батлагдсан зориулалтын төсвийг дагуу зарцуулж, өр авлага 2,96 үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлagnаж ажиллах	7.7	Төсвийн санхүүжилт, гүйцэтгэлийн дүн, сая төг	Санхүүжилт 2,452.0 Гүйцэтгэл 1,890.2	Санхүүжилт 2,967.7 Гүйцэтгэл 2,967.7	<p>Орон нутгийн төсвөөс 1,253,3 сая төгрөгийн санхүүжилт орж 731.9 сая төгрөгийг үр ашигтай зарцуулж ажилласан.</p> <p>Зардлын задаргаа:</p> <ul style="list-style-type: none"> - Цалин, хөлс 553,6 сая төгрөг - НДШ 63,1 сая төгрөг - Байрны ашиглалт 15,2 сая төгрөг - Хангамжийн материалын зардал 27,5 сая төгрөг - Бусад зардалд 4,1 сая төгрөг - Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 68,4 <p>Төсвийн гүйцэтгэлийн орлогын мэдээ, нийгмийн даатгалын тайланг https://portal.ndaatqal.mn цахим хуудсанд 5 удаа, 1-5 дугаар сарын борлуулалтын орлогыг төлбөрийн баримтын систем https://ebarimt.mn/pages/ хугацаанд нь гаргаж холбогдох газруудаар хянан баталгаажуулж, цахим мэдээллийн системд нийтэлсэн.</p>	100%
8.3	Арга хэмжээ 8.3 Нийслэлийн ёмчит үйлдвэрийн газарт олгосон нэмэлт санхүүжилтийг хуваарийн дагуу зарцуулах	-	Санхүүжилтийн дүн, Гүйцэтгэлийн хувь	100%	100%	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны нэмэлт санхүүжилт олгох 13 захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 25,521.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - A/14 дүгээр захирамжаар "Сэлбэ хорин минутын хот" корпораци 3,000.0 сая, - A/55 дугаар захирамжаар "Эмээлт эко аж үйлдвэрийн парк" ХК-ийн ийн 4,900.0 сая, - A/57 дугаар захирамжаар "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-ийн ийн санхүүжилт 3,000.0 сая, - A/54 дүгээр захирамжаар "Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮГ-ийн санхүүжилт 3,000.0 сая - A/126 дугаар захирамжаар " Налайх үйлдвэрлэлт технологийн парк" ХК-ийн ийн санхүүжилт 400.0 сая, 	100%

						<ul style="list-style-type: none"> - A/126 дугаар захирамжаар " Налайх үйлдвэрлэлт технологийн парк" ХК-ийн ийн санхүүжилт 400.0 сая, - A/190 дүгээр захирамжаар " Тархмал эрчим хүчний дэд бүтэц" ХХК-ийн ийн санхүүжилт 3,000.0 сая, - A/216 дугаар захирамжаар "Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨААТҮГ 416.5 сая, - A/517 дугаар захирамжаар " Улаанбаатар түншлэл төв" ХХК-ийн ийн санхүүжилт 1,824.4 сая, - A/89 дугаар захирамжаар "Бага хангай үйлдвэр технологийн парк" 300.0 сая, - A/458 дугаар захирамжаар "Дулааны 5-р цахилгаан станц" ОНӨААТҮГ 806.6 сая - A/502 дугаар захирамжаар "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ 3,033.4 сая, - A/591 дугаар захирамжаар "Түлиш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ 1,540.3 сая, - A/232 дугаар захирамжаар "Багануур үйлдвэр технологийн парк " ХК 300.0 сая. 	
9	Зорилт 9. Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулна.						
9.1	Арга хэмжээ 9.1 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдэн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Албан бичиг, өргөдөл гомдлын тоо, хэрэгжилтийн хувь	Албан бичиг 2055, 100% Өргөдөл 141, 100%	Албан бичиг , өргөдлийг 100% шийдвэрлэсэн байна.	<p>Тайлант хугацаанд нийт 1877 албан бичиг ирснээс хариутай 179, хариугүй 1698, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 94.44%, хариугүй бичгийн шийдвэрлэлийн хувь 98.99% байна. Нийт ирсэн бичгээс 1730 хугацаанд нь шийдвэрлэж, 147 албан бичиг судлагдаж байна. Албан хаагчид ирсэн бичгийг шийдвэрлэхдээ албан бичгийн стандартын дагуу үндэслэлтэй тайлбар бичсэн, 10 хоног тутам явцын тэмдэглэл бичсэн эсэхэд хяналт тавин ажилласан.</p> <p>Явуулсан албан нийт 971 албан бичгээс хариутай 77, хариугүй 894 байна. Ний 153 албан бичгийг шуудангаар буюу цаасан хэлбэрээр илгээсэн.</p>	100%

						<p>Байгууллагад нийт 72 өргөдөл гомдол ирснээс 66 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 6 өргөдөл гомдол судлагдаж байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног 17 цаг 6 минут байна. Тайлант хугацаанд шийдвэрлэсэн асуудлаар дахин гомдол гараагүй байна.</p> <p>Үүнээс Засгийн газрын 11-11 төвөөс 3 өргөдөл, гомдол ирснээс 100% шийдвэрлэж тус асуудлаар дахин гомдол гараагүй байна.</p>	
9.2	Арга хэмжээ 9.2 Баримт бичиг няглан шалгах комиссын ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	<p>Газрын даргын 2024 оны А/487 дугаар тушаалаар байгуулсан байгууллагын дэргэдэх "Баримт бичиг няглан шалгах комисс"-ыг байгуулж байгууллагын хөтлөх нэрийн жагсаалтын боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөх хэргийг архивд шилжүүлэхэд ажлын зохион байгуулж байна.</p> <p>Төрийн Архивын хэлтэст баримт шилжүүлэх зөвлөмжийн дагуу Нийслэлийн Архивын газрын Мэргэжил, арга зүйн зөвлөлийн V, VI хуралдаанаар хэлэлцүүлэн, БНШАЗК-ын 1 дүгээр хуралдаан, Төрийн архивын хэлтэст баримт шилжүүлэхээр тус тус хэлэлцүүлэн батлуулсан</p> <p>Баримт няглан шалгах комисс нь 2024.11.28-ний өдрийн 1 дүгээр хурлаар баримтыг дахин няглан шалгаж Төрийн архивд баримт шилжүүлэх байнга хадгалах 1380 баримтаас Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын 288 баримт, Төрийн болон орон нутгийн өмчийн дахин үнэлгээний 351 баримт, Ерөнхий боловсролын сургуулиудын Үдийн цайны хөтөлбөрийн түрээсийн гэрээ, түрээсийн гэрээний сонгон шалгаруулалтын баримт, Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ, болон ажил гүйцэтгэх гэрээ 117 баримт нийт 656 баримтыг түр хадгалах хадгаламжийн нэгжийн данс бүртгэлд, 2015-2022 оны хооронд үүссэн түр хадгалах баримтаас 149 баримтыг устгах хэргийн баримт руу УЖ тодорхойлон шилжүүлэн бүртгэл авч. Баримтыг дахин няглан шалгах явцад түр хадгалах 149 баримт нь хуулбарласан, давхардсан байсныг. хэлэлцүүлэн шийдвэрлэж устгах хэргийн данс руу</p>	100%

						шилжүүлэн бүртгэлийг үйлдэж, Нийслэлийн архивын дэргэдэх Төрийн Архивын хэлтэст байнга хадгалах 570 баримт, Захирамжлахын цахим 85 цаасан суурьт баримт, цахим сангийн 1 ширхэг hard-ийг хүлээлгэн ёгсөн байна. Нийслэлийн архивын газарт 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр Байгууллагын архивын тоон мэдээг хүргүүлсэн.	
9.3	Арга хэмжээ 9.3 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын архивын сан хемрөгийг бүрдүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Байгууллагын 2024 онд үүсэн архивын баримтыг мэргэжилтэн, албан хаагчдаас хуваарийн дагуу хүлээн авсан "байнга" -86, "тур"- 205, "70 жил" хадгалах 18, нийт 309 баримтыг хүлээн авч бүртгэлжүүлсэн. Байгууллагын 2025 оны "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг баталгаажуулж, 2025 оны III, IV улиралд зохион байгуулгадах "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-ийн бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна.	100%

Төлөвлөгөөг хянасан:
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөө тайлгагнасан:
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч

.....

/Х.НЯМБААТАР/

(гарын үсэг)

(огноо)



/В.ОЮУМАА/

.....
2025.06.12
(огноо)

Төсвийн Шууд захирагч

б. Асэльжид
(гарын үсэг)

.....
50